

ЕРӨӨ СУМЫН СОЁЛЫН ТӨВӨӨС 2024 ОНД ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2024.12.10

1.Хүний нөөцийг хөгжүүлэх идэвхжүүлэх чиглэлээр:

1.1. Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчийн мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэхээр зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан байдал:

2024 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хотод-2, Сэлэнгэ аймагт-7, Дархан-Уул аймагт-1, сумандаа 5, цахимаар- 14, байгууллагын дотоод сургалт-4 нийт 33 удаагийн сургалт семинарт хөгжмийн багш, номын санч, Соёлын төвийн дарга, бүжгийн багш, ОНСТанхимын ажилтан нар хамрагдлаа.



Байгууллагын албан хаагчдын цахим сургалт-14



Орон нутагт зохион байгуулсан сургалт- 5



1. 2024.03.19 Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-ийн танилцуулах сургалтанд хамрагдсан.
2. 2024.03.26 Мобиком компанийн зохион байгуулсан сургалтанд байгууллагын 2 албан хаагч хамрагдлаа.
3. 2024.04.03 Угийн бичгийн сургалтанд байгууллагын 3 албан хаагч хамрагдлаа
4. 2024.10.16 “Зорилгодоо хүрэх ур чадвар” сургалтанд байгууллагын 2 албан хаагч хамрагдлаа.
5. 2024.11.19-ны өдөр “Сүрьеэгүй Сэлэнгэ” аймгийн хөтөлбөрт танхимын сургалтанд байгууллагын 2 албан хаагч хамрагдлаа.

Байгууллагын дотоодын сургалт- 4

2024.02.26 нд Байгууллагын эцэг эхийн зөвлөлөөс “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдвээр сургалт зохион байгууллаа.

2024.03.27 Соёлын төвийн дэргэдэх номын сангаас албан хаагчдад Угийн бичиг хөтлөх арга” сэдвээр сургалтыг явууллаа.

2024 оны 04 дүгээр сарын 24 нд Албан хаагчдад “Гамшгаас урьдчилан сэргийлэх талаар” сургалт зохион байгууллаа.

2024 оны 11 дүгээр сарын 19-ны өдөр шинээр батлагдсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлах, мөн байгууллагын ёс зүйн талаарх сургалтыг байгууллагын албан хаагчдын дунд хийж, харилцан ярилцаж үр дүнтэй сургалт зохион байгуулсан.



Мэргэшүүлэх чиглэлээр: 2024 онд дарга, нягтлан бодогч, номын санч, хөгжмийн багш, бүжгийн багш, Орон нутаг сурталчлах танхимын ажилтан, үйлчлэгч гэсэн 6,5 орон тоотойгоор ажиллаж байна. Үүнээс:

Соёлын төвийн дарга, хөгжмийн багш нар мэргэжлийн,

Номын санч, ОНСТанхимын ажилтан, бүжгийн багш нар мэргэжлийн бус. Мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэн, цаашид орон нутагтаа тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор номын санч, ОНСТанхимын ажилтан нарыг СУИС-ийн эчнээ ангид суралцахад нь суралцах хугацааны цалинг нь 100% олгон ажиллаж байна.

Албан хаагчдыг байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр сургалтанд хамруулсан талаар:

Сумын Засаг даргаас аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний 12.1 дэх заалтын дагуу Номын санчаар суралцаж буй Ц.Болортуяад суралцах хугацаанд нь 1 удаагийн сургалтын төлбөрт нь **1,000,000** төгрөг, Соёлын өвийн ажилтанаар суралцаж байгаа ажилтан Б.Сэрчмаад **1,500,000** төгрөгний дэмжлэгийг тус тус үзүүллээ.

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

СОЁЛЫН ТӨВИЙН АЖИЛТАН  М.САНЧИР